



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-26</i>
<hr/>	
<i>1.Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</i>	<i>5-7</i>
<i>2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/</i>	<i>7-26</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 10 дугаар
сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 39 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, Д.Ганбат,
Б.Дэлгэрсайхан, Ж.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд.

Нэг.Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан уг асуудлыг дахин хэлэлцэж байгаа талаар тайлбар хийж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарас ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа үг хэлэв.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 2

Бүгд: 9

77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 9 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын Аудитын менежер Х.Баярмаа, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Аудитын удирдлагын менежер Л.Мөнхцацрал, Санхүү-нийцлийн аудитын газрын менежер Ц.Хосжаргал, П.Чанцалдулам, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мөн хэлтсийн мэргэжилтэн С.Гэлэгжунай, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мөн хэлтсийн ахлах шинжээч Д.Отгонжаргал, Н.Уранцэцэг, ахлах мэргэжилтэн Б.Дэнсмаа, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, мөн штабын Санхүүгийн хэлтсийн дарга Б.Бүрэнтөгс, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, мөн яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал Г.Өлзийсайхан, Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, Төрийн захиргааны удирдлагын газрын захирал Д.Амарсайхан, мөн газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Санхүү, ар талын газрын дарга Я.Гантөмөр, мөн газрын Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга Г.Манлайжав, мөн комиссын Ажлын албаны Тамгын газрын дарга Б.Баатарцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Төсвийн төслийн талаар Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд 09 цаг 50 минутаас хуралдааныг даргалав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Х.Баделхан, Н.Энхболд, Н.Наранбаатар, Б.Батгөмөр, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 22 минут үргэлжилж, 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн
хууль” танхим 09 цаг 39 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10 сарын 24-ний хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг чөлөөтэй, Ганибалын Амартүвшин чөлөөтэй Пүрэв-Очирын Анужин ирсэн, Хавдисламын Баделхан ирсэн, Энхтайваны Бат-Амгалан чөлөөтэй, Багаагийн Баттөмөр гишүүн ирсэн байна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Сүхбаатарын Батболд гишүүн өвчтэй байна, Дашдондогийн Ганбат гишүүн чөлөөтэй байна, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн чөлөөтэй байна, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна, Сэргэлэнгийн Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн байна, Дамдины Цогтбаатар гишүүн гадаадад томилолттой байна, Нямаагийн Энхболд гишүүн ирсэн байна, Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн чөлөөтэй байна.

Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1.Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд. Засгийн газар 2023 оны 9 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Эхний асуудал тусгай хяналтын дэд хорооны асуудал ажлын хэсэг байхгүй байна. Тайлбар өгчихье.

Байнгын хорооны энэ оны 10 сарын 17-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Багаагийн Баттөмөр, Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одтуяа нарыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилох саналыг дэмжиж Тусгай хянал хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2023 оны 10 сарын 19-ний өдөр Их Хурлын чуулганд өргөн мэдүүлсэн. Нэгдсэн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэлээс Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг намын бүлгээрээ дахин зөвшилцөх шаардлагатай тул Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4-т бүлэг болон бүлэг нэгдсэн болон Байнгын, түр хорооны хуралдааны үеэр тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах эрхтэй гэж Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 15.1-д заасан энэ хуульд өөрөөр заагаагүй нам эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33.1.4-т заасны дагуу завсарлага авах эрхтэй гэж заасны дагуу завсарлага авах санал гаргасан тул Улсын Их Хурлын дарга завсарлага олгосноор тухайн хэлэлцүүлэг

хойшлогдсон болно. Мөн АН-ын бүлгийн дарга О.Цогтгэрэл уг асуудлаар завсарлагын хугацаа дуусгавар болсон тухай Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд мэдэгдсэний дагуу Улсын Их Хурлын дарга Занданшатар энэ их асуудлыг дахин хэлэлцүүлэхээр Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн. Улсын Их Хурлын гишүүн Дашидондогийн Ганбатыг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилуулах тухай албан тоотыг Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга О.Цогтгэрэлээс Улсын Их Хурлын дарга Занданшатарт ирүүлсэн бөгөөд уг асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурал дээр хэлэлцүүлэхээр ирүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26.3-д заасны дагуу өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэж байна.

Байнгын хороонд Улсын Их Хурлын даргаас ирүүлсэн албан бичиг байна. Албан бичиг 2023 оны 10 сарын 20-ны өдөр дугаар 0130 гэсэн дугаартай дэд хорооны гишүүнээр томилуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 8.1.8, 33 дугаар зүйлийн 33.1.5 дахь заалтын дагуу Улсын Их Хурал дахь АН-ын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүн Салдангийн Одонтуяаг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилуулах хүсэлтүүдийг хүргүүлж байнгын хорооны хурлаар дэмжигдсэн байсан билээ. Гэвч Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүн Салдангийн Одонтуяагийн зүгээс тус дэд хорооны бүрэлдэхүүнд орохоос татгалзсан саналаа илэрхийлсэн тул түүний оронд Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүн Дашидондогийн Ганбат гээд Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр томилуулах хүсэлтийг хүргүүлж байна аа. Хүлээн авч,

шийдвэрлэж өгнө үү гэсэн ийм бичиг ирсэн байна. Уншиж танилцууллаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу? Салдангийн Одонтуяа гишүүнээр тасаллаа. Одонтуяа гишүүн үгээ хэлье.

С.Одонтуяа: Тэгэхээр өмнөх Байнгын хороо тогтоол баталчихсан байсан. Гэхдээ яах вэ бүлэг дээр дахиж яриад Ганбат гишүүн өөрөө онцгойлон хүсэлт гаргаж байгаа учраас би яах вэ нэрээ татсан байгаа. Тэгээд Ганбат гишүүнийг оруулахыг нь дэмжээд өгчихье. Тусгай хяналтын дэд хорооны гишүүдэд энд манай нэг нэлээн олон гишүүн байна. Би албан бичгээр нөгөө гол Тусгай хяналтын дэд хороон дээр шийдүүлэх гээд байгаа асуудлаа тус бүрд нь албан бичгээр хүргүүлье. Энийг сайн дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна.

Энэ бол нөгөө хар тамхитай холбоотой нэг асуудал байгаа.

Тэгэхээр Баттөмөр гишүүн ээ та орж байгаа юм байна манайхаас Энхболд гишүүн байгаа тэ, байхгүй юм уу? Тэгвэл Баттөмөр гишүүн байгаа юм байна та энэ дээр нь онцгой анхаарч дэмжлэг үзүүлээрэй гэж л хэлэх гэсэн юм.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулъя аа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.5 дахь хэсгийг үндэслэл Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн байгаагийн Баттөмөр, Дашидондогийн Ганбат нарыг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр

баталсугай. Энэ тогтоолыг баталсан төрөөс дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төслийг танилцуулж байна аа.

Тогтоолын төсөлтэй холбой асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Үг хэлж дууслаа.

Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 9 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 77.8%-ийн саналаар уг тогтоол дэмжигдлээ.

Санал хураалтын дүнг танилцуулсан.

Уг асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар гишүүн танилцуулъя.

09.46 цагт

Дараагийн асуудалд орѐе оо ажлын хэсгээ оруулъя. [Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.](#)

Ажлын хэсэг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн дэд сайд Санжаагийн Мөнгөнчимэг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, тус яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, тус яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, тус яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Батсүхийн Сүх-Очир, тус яамны Хөгжлийн санхүүжилт,

хөрөнгө оруулалтын газрын дарга Чимидсүрэн, тус яамны Хууль эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, тус яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, тус яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Тулга, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Дэлгэржаргал, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Сангийн яамны төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Отгонжаргал, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Уранцэцэг, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Дэнсмаа, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн Гэлэгжунай, Монгол Улсын Ерөнхий аудио аудитор Занданбат, Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Самбууням, Үндэсний аудитын газрын гүйцэтгэх-нийцлийн Аудитын газрын дарга Энхболд, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын менежер Мөнхцацрал, Үндэсний аудитын газрын гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын менежер Баярмаа, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн Чанцалдулам нар ирсэн байна.

Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Бригадын генерал Ганхуяг, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга дэд хурандаа Оюунгэрэл нар ирсэн байна.

ЗХЖШ-ын дарга Сүнрэвийн Ганбямба, ЗХЖШ-ын Санхүүгийн хэлтсийн дарга, хурандаа Бүрэнтөгс, Гадаад харилцааны яамны Нямдоржийн Анхбаяр, Гадаад харилцааны яамны

Төрийн нарийн бичгийн дарга, мөн яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал Өлзийсайхан, яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал Сүхболд, яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын захирал Амарсайхан, яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ганбат, ОБЕГ-ын дарга хошууч генерал Ариунбуян, ОБЕГ-ын Санхүү ар талын газрын дарга, хурандаа Гантөмөр, мөн газрын Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга ерөнхий нягтлан хошууч Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Манлайжав, Цөмийн энергийн комиссын ажлын албаны Тамгын газрын дарга Баатарцогт нар ирсэн байна аа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллагуудын төсвийн талаар танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна аа.

Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улсын эдийн засаг сайжирч улмаар урт хугацааны

хөгжлийн эхний 10 жилийн зорилт болох шинэ сэргэлтийн бодлого хэрэгжүүлэх боломж бүрдээд байна аа. Тиймээс шинэ сэргэлтийн бодлогын гол зорилтын нэг болох хот хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн төсөв санхүүгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр ирэх 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно оо.

Ирэх оны төсөвт Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлогыг бэхжүүлэх чиглэлээр тусгасан арга хэмжээг дурдвал хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн ил тод арилжааг эрчимжүүлэх,

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум, мод, хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, хүнсний ногоо, газар тариалангийн ажлын явц бүсийн хэмжээний үйл ажиллагаа явуулдаг технологийн парк, мах, ноос, арьс шир, түүхий эд, хүнс, сүү боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжих,

3. Төрийн цэргийн байгууллагын үүрэг гүйцэтгэх бэлэн байдал болон аюулгүй байдлын чадавхыг бэхжүүлэх, офицер, ахлагч, хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчдыг дүрэмт хувцас хэрэглэлээр хангах, Хоол хүнс, шатах тослох материал, хээрийн дадлага, сургуулилт, машин, тоног төхөөрөмжийн хэрэгслийн засвар үйлчилгээ болон оюутан цэрэг хөтөлбөрийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээнд шаардлагатай зардлыг холбогдох хууль, тогтоомж эрх зүйн актуудад заасны дагуу тооцон тусгасан болно. Шинэ сэргэлтийн бодлогыг дэмжих багц арга хэмжээг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25.3 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 27.4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2,1 их наяд

төгрөг буюу ДНБ-ний 2.8 хувь болж төсвийн тусгай шаардлагыг хангаж байгаа болно оо.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Ирэх оны төсвийн төсөлд улсын аюулгүй байдал, гадаад бодлогыг бэхжүүлэх чиглэлдээ тусгасан арга хэмжээтэй танилцаж Монгол Улсын 2024 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны Төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Манай Байнгын хорооны эрхийн асуудлын хүрээнд хамаарах байгууллагуудын төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат хийнэ ээ.

Занданбат дарга 3 дугаар микрофон өгөөрэй.

Д.Занданбат: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж чиглэсэн эсэхийг 7 зорилтын хүрээнд

хянаж үнэлэхэд аудитын зорилго чиглэсэн.

Төрийн аудитын байгууллага нь төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн гэж дүгнэж байна аа.

Үүнд: Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл ДНБ-д эзлэх харьцаа 2024 онд 40.7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв санхүүгийн аюулгүй байдлын зохистой харьцаанд байна.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.2 хувь, нийт зарлага 27 их наяд буюу 360.7 тэрбум төгрөг буюу 27 их наяд 360.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 37 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70.8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ний -2.8 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоод ДНБ-ний 2 хувиас илүүгүй алдагдалтай, 19 дүгээр зүйлийн 19.9-д 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх. Төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн хувь тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн дунджийн аль эхээс хэтрэхгүй байх, Засгийн газрын өрийн

өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ний 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байна аа. Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг боловсруулахад Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан дараах зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Үүнд: Шинэ сэргэлтийн бодлогод тусгасан хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, экспортыг дэмжих, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг эрчимжүүлэх, иргэдийн орлогыг хамгаалж, цалин, тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, хөгжилд суурилсан хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэд, эх орондоо оношлогдон эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх, уул уурхайн орлогоос орон нутгийн хөгжлийн санд нэмэлт орлого хуваарилах, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулах, тогтвортой, хариуцлагатай уул уурхайг дэмжиж байгалийн баялгийн үр өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлэх зэрэг болно.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2024 оны төсвийн төсөвт тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдлаар төлөвлөжээ. Гадаад харилцааны сайд төвлөрүүлэх орлогыг 6 тэрбум төгрөг, зардлыг 194.2 тэрбум төгрөг, Батлан хамгаалахын сайд төвлөрүүлэх орлогыг 38.2 тэрбум төгрөг, зардлыг 564.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна аа. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2023 оны тодотгосон төсвөөс 209.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 758.7 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн нь Монгол Улсын Хилийн тухай хуулийн 7.1.16-д заасны дагуу цэргийн анги

салбарт ажиллаж байгаа офицер ахлагчийн сургуулийн насны хүүхдийн боловсролыг дэмжих зорилгоор олгодог тэтгэмжийг 660 мянган төгрөг болгохоор төлөвлөсөн.

Засгийн газраас 2024 онд нийт албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэх бодлого баримталсан зэрэгтэй холбоотой байна аа.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр нь алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго зорилттой нийцэж буй хэдий ч Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээнээс Гадаад харилцааны яаманд дараах 2 хөтөлбөр арга хэмжээг тусгаагүй байна аа.

Үүнд: Төмөр замын Эрээн цав боомтыг олон улсын зэрэглэлтэй болгох, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор виз олголтыг хялбаршуулах, визгүй зорчих боломжийг бүрдүүлэх. Тус байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны төсвийн багцад нийт 26.8 тэрбум төгрөгийн 8 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 25.1 тэрбум төгрөгийн 7 төсөл арга хэмжээ нь тусгагдаж байна аа.

Үр дүнд чиглэсэн төсөвлөлтийн аргыг улсын болон орон нутаг мөн салбарын төсөвлөлтөд хэрэгжүүлснээс бий болгох, үр өгөөж, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор хэмжих үзүүлэлтийг тодорхой болгож хүрэх үр дүнг богино дунд хугацаагаар тодорхойлж үйл ажиллагааг хэмжэсэнээр төсвийн зардлын ашиглалт, үр өгөөж нэмэгдэж, төсөвлөсөн хөтөлбөр бүрэн хэрэгжүүлэх боломжтой байна аа.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Монгол

Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дараах дүгнэлтийг танилцуулъя аа.

Үүнд:

1.Төсвийн төсөлд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, татварын орлого зэргийг өөдрөгөөр төсөөлсөн нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл үүсвэл төсөвт тодотгол хийх нөхцөлд хүрч хүргэж болзошгүй байна.

2.Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй арга хэмжээний хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүйгээс төсвийн зорилго хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна.

3.Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний саналыг эрэмбэлэх. Эдийн засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт биш ашигтай уялдуулан эдийн засгийн бодит үр өгөөжийн тооцоо судалгаа хийх аргачлалыг боловсруулан баталж, өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.11 дэх заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.Гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн алдагдлын тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна.

5.Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд магадлал хийгдэж байгаа 21, 1 маягаар болон жишиг магадлалтай 153 төсөл арга хэмжээг тус тус тусгасан байна. Барилга байгууламжид зураг

төсөл, магадлал хийх, худалдан авах ажиллагаа, зохион байгуулах, гэрээ байгуулах, захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, улсын комисс, барилга байгууламжийг хүлээн авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан субъектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд дараах асуудлыг толилуулж байна аа.

Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусгуулахад анхаарах, өмнөх аудитаар толилуулсан төсвийн төслийг үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг үнэлж дүгнэх арга аргачлал шалгуур үзүүлэлтийг холбогдох хууль үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгах тухай өгсөн асуудлыг энэ жил дахин толилуулж байгааг анхаарахыг хүсэж байна аа.

Монгол Улсын Засгийн газар дараа оны төсвийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барихдаа төрийн аудитын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. Монгол Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихдаа төсвийн төсөл боловсруулах тухайн үе дэх хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх, улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн, зөвхөн төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх. Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй шалтгаан нөхцөлд нарийвчилсан судалгаа дүн шинжилгээ

хийж холбогдох арга хэмжээг авч ажиллах, Барилга байгууламжид зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах худалдан авах үйл ажиллагаа гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх, улсын комисс хүлээн авах үйл ажиллагаанд субъектив сөрөг нөлөөлөлгүй байлгах тодорхой нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгч, хэрэгжилтэд нь хяналт тавих.

Хөгжлийн бодлогод нийцүүлсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж чадавхыг нь сайжруулах зэрэг байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Занданбат даргад баярлалаа.

Өнөөдөр манай Байнгын хороогоор байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Цөмийн энергийн комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яамны төсвүүдийг хэлэлцэж байгаа.

Төсвийн талаарх танилцуулгыг Жавхлан сайд, түүнд хийсэн дүгнэлтийн талаар Занданбат дарга танилцууллаа.

Хуулийн төсөл, аудитын дүгнэлттэй холбогдуулаад асуух гишүүд байвал нэрээ өгье. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Одонтуяа гишүүн асууя.

С.Одонтуяа: Надад ганцхан энэ онцгой байдалтай холбоотой асуулт байна.

Сая зун Улаанбаатар хотод үерийн усны аюул нөмөрсөн. Энд бол маш их хохирол амссан. Ер нь Монгол Улс л энэ аюул осолд бас бэлэн биш байна гэдэг дээр бүх хүн санал нийлж байгаа юм.

Тэгэхээр газар хөдлөлтийн асуудал дээр ямар нэгэн төсөв хөрөнгө тавьсан уу? Энэ дээрээ ер нь анхаарч байна уу гэдгийг асуумаар байна. 5 сарын Аюулгүй байдлын байнгын хороон дээр байх аа би бас санал гаргаад асуулт тавиад Байнгын хороон дээр хаалттай хуралдсан. Энэ хурал дээр ямар дүгнэлтэд хүрсэн бэ гэхээр ерөөсөө Монгол Улс бол ямар ч бэлэн биш байна. Энэ ялангуяа газар хөдлөлтийн асуудал дээр бэлэн биш байна. Маш олон байгууллагууд уялдаа холбоогүй байна. Төсөв хөрөнгө хангалтгүй байна, газар хөдлөлтөд тэсвэртэй, тэсвэргүй энэ дүгнэлтүүд хангалттай хийгдэхгүй байна гэсэн ийм саналууд гараад чухамхүү бүгдээрээ энэ дээр л анхааръя ёстой маш хүнд байдалд байгаа юм байна, арай ч дээ ийм зүйл байсан юм уу гээд л халаглаад гарсан.

Энэний дараа бүх яамдуудаас би бас саналыг нь нэгтгээд Жавхлан сайдад хүргүүлсэн байгаа. Онцгой байдлын сайдад өөрийн биеэр бүүр биечилж уулзаж энэ асуудлыг ярьсан. Тэгэхээр энэ дээр анхаарч байгаа юм уу? Энэ Байнгын хорооны Монгол Улсын аюулгүй байдлыг гартаа атгаад сууж байгаа хэлж болохоор Байнгын хороон дарга, Байнгын хорооны гишүүд энэ дээр ямар бодолтой байгаа юм бэ? Энэ дээр төсөв хөрөнгө тавихгүй байж байгаад ямар нэг том эрсдэл гарахад хариуцлагыг нь хэн хүлээх вэ гэдэг ийм зүйлийг л яримаар байна.

Тэгээд мөнгө байхгүй юу гэвэл байгаа. Одоо жишээлэхэд өдөр болгон ордонд ямар ч шаардлагагүй хурал семинарууд болдог. Энэ нэг өртөг нь гэхэд 100-аас 110 сая. Одоо тэгээд сонгуулийн жил гээд бүүр их эрх баригчид гарын бэлэгтэй нь өгөх байх л даа. Тэгэхээр гарын бэлэг нь орвол бүүр ингээд 200 сая 1 л өдрийн арга хэмжээ шүү дээ.

Тэгэхээр мөнгө ер нь зүгээр гаргая гэвэл байгаа. Тэгээд ер нь энэ хүн ардын аюулгүй байдалтай холбоотой зүйл дээр бид нар мөнгө харамлаж болохгүй ээ. Одоо та нар энэ сургууль, цэцэрлэгийн байдлууд ямар байна хар. Хуучны барилгууд доод тал нь дандаа ингээд багануудаа нураагаад ерөөсөө хэзээ мөдгүй нурахад бэлэн болчихсон ийм байшингууд яах юм? Энэ дээр ер нь улсын бодлого гэж байна уу? Зүгээр яах вэ энэ түрүүн нөгөө чуулган дээр намайг асуухад ингээж хариулж байна лээ. Онцгой байдлын нөгөө нөөц хөрөнгө байгаа. Тэр чинь бол аюул гарсан үед бид нар ерөнхийд нь хэрэглэхээс биш нөөц хөрөнгийг чинь. Одоо бол бид нар улсын төсвөөсөө бүр бодлогоор төсөв тавиад энэ дээр ажиллаж байх ёстой юм аа. Тэгээд энэ дээрээ ямар нэгэн төсөв хөрөнгө тавьсан юм уу? Би яах вэ энэ юунуудыг харчихлаа. Энэ баахан сургалтын төвийн барилгууд гээд байна л л даа. Энэ бол яах вэ мэдээж сургалтын төв байх ёстой. Тэгэхдээ ер нь бол зүгээр манай БГД-ийн нутаг дэвсгэр дээр нийслэлийн онцгой байдлын төв гэж байдаг юм. Сургалтын төв. Маши гоё төв бас байгуулагдсан. Тэгэхэд тэр бол маши ашиглалт муутай байдаг юм шүү дээ. Би л хааяа нэг хүүхдүүд аваачаад сургалтын төв рүү нь оруулж хичээл ном хийлгэж байхад ер нь их тийм юу багатай.

Тэгэхээр энэ дээр хариулт өгөөч ээ гэсэн асуулт байна. Энэ дээр тэгээд ер нь хариуцлагаа хүлээх боломжтой юу гэдгийг асууя.

Н.Энхболд: Онцгой байдлын ерөнхий газар хэдэн номер дээр байна? Тэр 3 номерын микрофон дээр очоод суугаадах, Ариунбуян генерал. Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг өгье.

Г.Ариунбуян: Одонтуяа гишүүний асуудалд хариулъя. Ер нь бол газар хөдлөлтийн чичирхийлэлд давтамж учруулж байгаа хохирлын хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж байна. Ер нь цаашидаа ч гэсэн энэ эрдэмтдийн

судалгаагаар нэмэгдэх ийм хандлагатай байна гэсэн ийм тооцоот дүнг танилцуулж байгаа. Тэгээд ер нь газар хөдлөлтийн гамшигаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээнүүд авч явж байгаа хэдий ч бас төсвийн боломж бас төдийлөн бүрдэхгүй байна гэдэг асуудлыг та тавьж байна.

Тэгэхдээ бол Монгол Улсын Засгийн газраас бас энэ гамшигийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх ялангуяа гамшигийн бэлэн байдлыг сайжруулах чиглэлээр Азийн хөгжлийн банкттай 30 сая долларын өртөг бүхий томоохон төслийг хэрэгжүүлэхээр ийм шийдвэр гараад ажиллаж байгаа. Энэ хүрээнд бүх газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд байгаа ард иргэдэд сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийг цаг алдалгүй өгөх, ялангуяа олон нийтийн сүлжээгээр дамжуулж энэ эрсдэлийн мэдээллийг цаг алдалгүй өгөх ийм техникийн боломж бүрдэнэ.

Хоёрдугаарт, Онцгой байдлын ерөнхий газрын бүсийн төвүүдийг шуурхай удирдах зохицуулалтын нэгдсэн тогтолцоонд оруулах ийм нөхцөл нь бүрдэх юм аа. Энэ бол ингээд 4 жилээс 5 жилийн хугацаанд хэрэгжих ийм том төсөл байгаа.

Газар хөдлөлтийн гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх тал дээр бол Сангийн яам бас нэлээн анхаарал тавьсан. Тэгээд энэ хүрээнд энэ жил 9 орчим тэрбум төгрөгийн ялангуяа энэ техник тоног төхөөрөмжийн 50 орчим хувь нь хот доторх аврах, эрэн хайх, аврах ажиллагааны багаж тоног төхөөрөмжүүд байх юм. Манай аврагчдын нэн шаардлагатай энэ багаж тоног төхөөрөмжүүд байна.

Бусад тэр газар хөдлөлт үертэй холбоотой асуудал дээр бол нийслэл, аймаг орон нутаг бас өөрсдийнхөө гамшигийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн хүрээнд батлагдсан ийм санхүүжилтээр

бас тодорхой хэмжээнд шийдээд явах ийм боломжтой байна.

Н.Энхболд: Болсон уу? Одонтуяа гишүүн тодруулъя.

С.Одонтуяа: Энэ Азийн хөгжлийн банкны 30 сая еврогийн төсөл нь яг хэзээнээс хэрэгжиж эхлэх вэ? Тэрэн дээр бол техник тоног, төхөөрөмж юмнууд хийх юм байна. Ер нь бол энэ газар хөдлөлтийн асуудалд бол асуудалгүй ээ бүх юм бэлэн гэж таныг хариуллаа гэж ойлголоо.

Н.Энхболд: Ариунбуян генерал, 3 номерын микрофон.

Г.Ариунбуян: Энэ Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлэх төсөл маань 2024 оноос 2028 оны хооронд хэрэгжих ийм төсөл байгаа. Улсын хэмжээнд гамшигийн аюулын зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоо ийм бүрдүүлэх төсөл. Ер нь бол бэлэн байдал бүрэн хангагдана уу гэдэг асуудал өөрөө учир дутагдалтай. Энэ газар хөдлөлтийн энэ аюулыг бүртгэх ийм станц нь бол Шинжлэх ухаан академид байдаггүй. Өөрөөр хэлэх юм газар хөдлөлтийг бүртгэдэг Одон орон геофизикийн хүрээлэнд энэ нь бол хамаардаг.

Тийм учраас энэ тусдаа төсвийн зохицуулалттай явна.

Аймаг орон нутаг дахь акселерометрийн бүртгэлийн станцууд нь тухайн орон нутагтаа бүртгэлтэй байх жишээний. Тэгэхээр энэ чиглэлээр бид нар зөвлөмжөө өгөөд аймаг, орон нутаг тухайн байгууллага энэ 2024 оны төсөвтөө энэ талаар тусгаж ажиллаач.

Н.Энхболд: Жавхлан сайд нэмэх зүйл байвал тодотгоё.

Б.Жавхлан: Одонтуяа гишүүний асуултад нэмж зүгээр мэдээлэл өгөх гэсэн юм аа. Аливаа гамшигаас урьдчилан сэргийлэх, гамшигийн үед, гамшигийн дараа

тийм 3 чиглэлээр бид бэлтгэл хангаж, урьдчилан сэргийлж ингэж ажиллах ёстой, ингэж төсөвлөх ёстой хуулиараа ийм байгаа.

Ер нь дэлхий нийтээрээ энэ гамшиг газар хөдлөлтийг урьдчилж мэдээд, урьдчилж сэргийлээд яг тэнд тэдэн баллын газар тэдэн секунд хөдөлгөж байна гэдэг төгс шийдэл одоогоор хүн төрөлхтөн олоогүй байгаа л гэж бодож байгаа. Тэгэхээр гамшигийн дараах гарсан хохирол юмыг аль болох хурдан хугацаанд энийг арилгах гээд энэ төсөвлөж байгаа мөнгөнүүд энэ Засгийн газрын нөөц болон гамшигаас хамгаалах хуулиараа өөрөө аливаа байгууллага, ялангуяа төсвийн байгууллагууд төсвийн зардлынхаа нэг хувийг энд зориулах ёстой гэсэн ийм хууль байдаг.

Н.Энхболд: Баделхан гишүүн асууя.

Х.Баделхан: Баярлалаа. Өмнөх Байнгын хорооны хурлуудаар энэ Батлан хамгаалах яамны техник хэрэгслийн шинэчлэл, тэгээд офицер, албан хаагч нарын хувцасны хангалтын талаар маш их шүүмжлэл яригддаг байсан. Ерөөсөө хувцсаа бол хугацаандаа нормт хугацаандаа сольж чадахгүй байна гэж. Техник хэрэгсэл бол бараг 60, 70-аад оны техник хэрэгсэл ер нь бараг шинэчлээгүй байна. Шинэчлэх боломжгүй улсын төсөв боломжгүй байна гэж олон жил явсан. Одоо бол манай улсын төсвийн орлогод давж биелэгдсэн. Төсөв маань тэлж байна. Ирэх жилийн төсөв бол нэлээн сайн төсөв болсон гэж бид нар ярьж байгаа л даа. Тэгэхлээр яг энэ тал дээр төсөв дээр туссан юм юу байна.

Тухайлбал, офицер, албан хаагч нар яг нормт хувцсаа хугацаандаа солих боломж бүрдсэн үү?

Хоёр дахь нь Батлан хамгаалах яамны техник хэрэгслийн шинэчлэл дээр анхаарахгүй бол болохгүй гэж өмнө нь манай Байнгын хорооноос хэд хэдэн удаа

шийдвэр гаргаж байсан. Яг энэ тал дээр хэр хэмжээний мөнгө тавигдсан юм гэсэн 2 асуулт байна аа? Баярлалаа.

Н.Энхболд: Сайханбаяр сайд хариулъя. 2 дугаар микрофон ажлын хэсгийн. Нэмэх шаардлага гарвал Ганбямба генерал нэмж болно.

Г.Сайханбаяр: Баделхан гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр 2024 оны Батлан хамгаалахын төсөв дээр хугацаат цэргийн албан хаагчид болон офицер ахлагч нарын хувцасны нормт хангалтын асуудал дээр Сангийн яамнаас нэлээн анхаарсан. Сүүлийн жилүүдэд дунджаар авч үзэх юм бол хувцасны хангалтын төсвийн хуваарилалт 25-35 хувьтай тавигдаж байсан бол 2024 оны хувцасны хангалтын төсөв нэг 60 орчим хувиар тавигдсан. Тэгээд энэ бол бас манай салбарын хувьд 2024 онд нийт офицер, ахлагч нарынхаа хувцасны 60 орчим хувийг хугацаат цэргийн албан хаагчдад 100 хувиар хангах боломж бүрдэж байгаа. Хүнсний хангалтын хувьд бол мөн ялгаа байхгүй. Бас 35 орчим хувийн нэмэгдэл төсөвтэйгөөр батлагдаж байгаа.

Тэгээд ер нь 2024 оны төсөв дээр Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны N/4 тоот тогтоол гарсан. Батлан хамгаалахтай холбоотой тэр тогтоолын хэрэгжилтийг хангах талаар бас онцгой анхаарч ялангуяа энэ урсгал төсөв дээр хугацаат цэргийн албан хаагчид цэргийн албан хаагчдын цалин хөлс, хувцас, хүнс, шатахуун, сургалтын зардал дээр нэлээд анхаарч баталж өгч байгаа гэдгийг бас энд хэлэх хэрэгтэй байна.

Хоёр дахь асуудал зэвсэглэл техникийн шинэчлэлийн асуудал дээр манай Засгийн газар 2020 оноос бас нэлээн энэ анхаарч жил бүр тодорхой санхүүжилтийг суулгаж ирсэн. Үүний үр дүнд Монгол Улс үндэсний зэвсэг галт

хэрэгслийн үйлдвэртэй болсон. Энэ жил зэвсэг, сум галт хэрэгслийн үйлдвэр ашиглалтад орно. Одоогоор конвер үйлдвэрийнхээ тоног төхөөрөмжийг эхний татан авалтуудыг хийгээд байна. Ирэх жилээс дотоодынхоо хэрэгцээг хангах үйлдвэрлэлийг хийж эхэлнэ ээ.

Хөрөнгө оруулалтын зардал дээр бол ирэх жил тоног төхөөрөмжийн шинэчлэл гэдэг дээр бас тодорхой хэмжээний 8.7 тэрбум төгрөг нийтдээ 13 орчим тэрбум төгрөг тавьсан. Энэ нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа багийн техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, хөрөнгө оруулалтын зардлыг тусгаж өгсөн байгаа. Тийм учраас ер нь бол Сангийн яамнаас Батлан хамгаалах яамнаас баримталж байгаа бодлогын түвшинд энэ ирэх 2024 оны төсөв нэлээн өөдрөг төсөөлж байгаа гэдгийг хэлье.

Н.Энхболд: Би нэг юм тодруулаад асуучихъя.

Энэ нөгөө Польшийн тусламжаар барьсан цэргийн хээрийн 2 эмнэлгийн тухай асуудал бий. Тийм ээ? Энийг хүмүүс гадуур нэг алга болчихсон юм шиг хэрэглэхгүй болчихсон юм шиг, ашиглаад идээд уугаад дуусгасан юм шиг юм яриад байх юм. Энэ дээр хаана байгаа вэ? Ямархуу нөхцөл байдалтай байгаа вэ гэдэг талаар Сайханбаяр сайд, Ариунбуян генерал хоёр товчхон товчхон мэдээлэл өгөөдхөөч. Энэнийг тэр буруу мэдээллийг залруулахгүй бас гадуур тийм ойлголт яваад байдаг юм байна.

Г.Сайханбаяр: Энэ 2 дугаар шатын эмнэлэгтэй холбоотой асуудал шинэ эмнэлгийн асуудлыг ер нь иргэд нэлээн сонирхоод байгаа. Польшийн хөрөнгө оруулалтаар орж ирсэн. Нэг нь Онцгой байдлын ерөнхий газар дээр байх ёстой, нэг манай дээр бол шинэ эмнэлэг байгаа.

Дээрээс нь өмнө нь хойд Суданд үүрэг гүйцэтгэж байсан 2 дугаар шатны

нөөцийн 3 эмнэлэг байгаа манай дээр. Дээрээс нь энэ 2021 онд орж ирсэн 2 дугаар шатны шинэ эмнэлэг дадлага сургуулилалтаа хийгээд Онцгой байдлын ерөнхий газартаа тусгайлсан сургалтаа, дадлагаа хийгээд эргээд хадгалалт консервац тавьчихсан байж байгаа гэдгийг хэлэх гэсэн юм.

Н.Энхболд: Ариунбуян генерал товчхон. 3 дугаар микрофон.

Г.Ариунбуян: Польшийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нийлүүлэгдсэн эмнэлэг манай Үндэсний аврах бригадын агуулахад хадгалагдаж байгаа. Энэ эмнэлгийг бид команд штабын томоохон сургууль, иж бүрэн сургуулийн үеэр хэрэглэсэн. Өнгөрсөн хавар Баянхонгор аймагт зохион байгуулсан Гамшигаас хамгаалах иж бүрэн сургуулиар энэ эмнэлгийг дэлгээж гамшигийн үед тусламж үйлчилгээ үзүүлэх дадлага сургуулийг зохион байгуулсан.

Н.Энхболд: Байнга ашиглагдаж байгаа. 2 эмнэлгийн хувьд хоёулаа байгаа. Ашиглагдаж байгаа. Цаашидаа ч ашиглагдахад бэлэн байгаа гэж мэдээлэл өглөө гэж ойлголоо тийм ээ.

Наранбаатар гишүүн асууя.

Н.Наранбаатар: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Энэ төсвийн төсөлтэй бас танилцлаа. Батлан хамгаалах салбарын албан хаагчдын цалинг 4 сарын 1-нээс 10-10 хувиар нэмэгдүүлэх мөн аймаг энэ төв нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт байгаа төрийн албан хаагчдын сар бүрийн үндсэн цалингийн 20 хувиар суманд байгаа төрийн албан хаагчдын сар бүрийн үндсэн цалингийн 40 хувиар тооцож нэмэгдэл олгоно гээд. Тэгээд энийг би ойлгохдоо тэр аймаг сумд байгаа 20, 40-ийг нь орон нутгийн нэмэгдэл гэж ойлгоод байгаа юм. Мөн үү? Орон нутгийн нэмэгдлийг зөвхөн төрийн үйлчилгээний албан хаагчид нь олгож байгаа юу? Офицер ахлагч нарт

бол олгохгүй байгаа байх гэж ойлгож байна. Тэгэхээр хууль дагаж орж ирж байгаа, төсөв дагаж орж ирж байгаа Төрийн албаны хуульд бол энэ жилээс төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгож болно гээд олгоод явж байгаа. 2024 оноос эхлээд төрийн захиргааных дээрээ нэмээд төрийн үйлчилгээний болон улс төрийн албан тушаалтнуудын орон нутгийн нэмэгдэл олгох боломжийг нь нээгээд өгчихсөн байгаа.

Төрийн тусгай албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийн асуудлыг орхичхоод байгаа юм аа. Тэгээд би энэ дээр л гол нь Төрийн албаны хуульд ганц үлдчихсэн байгаа төрийн тусгай албан хаагчдын энэ орон нутгийн нэмэгдлийн асуудлыг нээгээд өгчихвөл бас боломж нь байгаа юм болов уу гэж. Яагаад гэхээр хөдөө орон нутагт ялангуяа суманд энэ алслагдсан суманд аймагт ажиллах энэ боловсон хүчний асуудал бас хүндээр тусгаад байгаа юм аа.

Ялангуяа энэ уул уурхайтай энэ аймгуудын хувьд бол бас төрийн албан хаагчид уул уурхайн компанид орж ажиллах ийм хандлага сүүлийн үед ихсэж байгаа. Ялангуяа энэ төрийн тусгай албанд ажиллаж байгаа онцгой байдлын албанд ажиллаж байгаа ийм улсуудыг бол уул уурхайн компаниуд бас өндөр цалин амлаж шилжүүлж аваад байгаа асуудал бас харагдаж байгаа. Тэгээд энэ дээр бас анхаарч, тухайн төрийн албан хаагчдыг тогтвортой хөдөө орон орон нутагт ажиллуулахад хамгийн том хөшүүрэг бол энэ орон нутгийн нэмэгдэл байгаа.

Тэгэхээр зэрэг энэ зарим газрууд, зарим аймгууд бол бас орон нутгийг өөрийгөө санхүүжүүлдэг бололцоотой аймгууд нь бас боловсон хүчнээ тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс орон нутгийн нэмэгдлийг өгөх ийм боломж бас байгаад байгаа юм. Тийм учраас энэ Төрийн албаны хуульд энэ төрийн захиргаа улс төрийн албан тушаал, төрийн үйлчилгээний, дээрээс нь нэмээд

төрийн тусгай албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийн асуудлыг нээгээд өгчих боломж байна уу үгүй юу.

Хэрвээ нээгээд өгчих юм бол энэ улсын төсөв дээр ямар нэгэн нэмэлт зардал шаардлага байхгүй. Орон нутаг төсвөөсөө ишидээд тодорхой нэмэгдлүүдийг нэмээд өгчих ийм бас боломж харагдаад байгаа юм. Энэ дээр ямар боломж байна гэж асууя, дараа нь тодруулъя.

Н.Энхболд: Жавхлан сайд хариулах нь зөв байх.

Б.Жавхлан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Ер нь энэ асуулт маань Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хариулдаг асуулт болсон шүү. Цалин, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой нэмэгдэлтэй холбоотой энэ зүйлийг. Өмнө нь салбар салбарын хуулиар ингээд зохицуулаад ер нь энэ талаар нэг тараагаад хаячихсан. Тэгээд энийг бол зөвхөн Засгийн газар дээр нэг л яам базаж бодлого нэг цонхоор явна гээд. Яах вэ төсөв дээр нь бид нар хамтарч ажиллаж байгаа учраас би хариулъя. Ийм байгаа. Төрийн тусгай, хил, онцгойгийнхон маань энэ орон нутгийн нэмэгдэл гэж байхгүй хэдий ч нэмэгдлүүд ТЗ, ТҮ-гийнхнээс хамаагүй өндөр, бүүр хэд дахин өндөр шүү. Яах вэ одоо ингээд ТЗ, ТҮ ингээд босоо, хэвтээ бүгд ингээд нэмэгдэж байгаа юм. Ялангуяа ТҮ дээр манай сургуулийн жишээ нь орон нутагт байгаа багш ажилчид нь бол албан тушаалаасаа хамаараад бас хөдөө орон нутгийн нэмэгдлүүд нь өөр өөр байдаг байсныг албан тушаалаас нь биш, яг газар зүйн байрлалаараа орон нутагт ажиллаж байгаа бол бүгд ижилхэн аймгийн төв дээрээ бол 20, суманд 40 авдаг байхаар ингэж нэмэгдэж байгаа. Ингэж нэмэгдээд, нэмэгдээд одоо байгаа төрийн тусгайгийнхны нэмэгдлүүдэд хүрэхгүй. Төрийн тусгайгийнхан жишээ нь 5 жил тутам буюу 60 сар тутам, 30 сарын нэмэгдэл авдаг, 5 жил тутам. ТЗ-

ийнхэн одоо дөнгөж 5 жил тутам 6 сар болж ирж байгаа, хавтгайрч ирж байгаа гэсэн үг. Удахгүй ТЗ-ийнхэн барьцаад бас 5 жил тутам 30 сар буюу ийм нэмэгдэл авдаг болно гээд хойтонгоос тэгж орж ирэх байх, барьцаад. Ар араасаа л ингээд явчихдаг л даа.

Тийм учраас одоохондоо бүгдээрээ энэ хэргийг бас тэгж шуурч болохгүй ээ. Одоо байгаа нэмэгдлүүд бол ер нь боломжийн байгаа. Төрийн тусгай гэж ярих юм бол манай гаалийнхан бас орж ирэх нь. Төрийн тусгай дээр гаалийнхан нэмэгдэл байхгүй нөгөө 5 жил тутам нь бүүр 0 гээд орчихсон байгаа. Бусад ТТ-үүд нь 5 жил тутам 30 сар. 30 сар биш юм гэхэд нэг 12 сар ядаж байж болдоггүй юм уу гээд энэ удаа төсөл орж ирсэн байгаа. Тэрийг харин дэмжиж өгөөрэй. ТЗ, ТҮ-гийнхэн бол 6 сар гэж шинээр орж ирсэн байгаа.

Н.Энхболд: Наранбаатар гишүүн нэмж асууя.

Н.Наранбаатар: Зэвсэгт хүчний нөгөө хөдөө орон нутагт ажиллаж байгаа албан хаагчид 5 жилийн урамшуулал авч байгаа юм уу? Авч байгаа бол хэдий хэмжээгээр хэдэн сараар 5 жил тутамд авч байгаа юм бол? Ганхуяг дарга хариулах уу? Хэн хариулах уу? Сайханбаяр сайд.

Г.Сайханбаяр: Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Энэ алслагдсанд тооцох анги салбаруудын жагсаалт гэж Засгийн газрын тогтоолоор батлагддаг. Аймгийн төвүүд энэ дээр хамрагддаггүй. Ялангуяа сумдад байгаа. Алслагдсан сумд дээр байж байгаа анги, салбаруудын офицер ахлагч нар 5 жил тутамд 60 хүртэл сарын тэтгэмжийг авч явж байгаа. Энэ тогтоолд зааснаар бол аймгуудын төвд байгаа аймгуудаас зөвхөн Баян-Өлгий аймаг өнгөрсөн жил Засгийн газрын тогтоолоор орсон байгаа. Бусад аймгууд ордоггүй. Зүгээр хүнсний нэмэгдэл, тусгай

онцгой нөхцөлийн нэмэгдэл гээд энэ бас орон нутагт нэмэгдэж тавьдаг зүйлүүд байгаа.

Н.Энхболд: Болсон уу? Баттөмөр гишүүн асууя. Баттөмөр гишүүний микрофон.

Б.Баттөмөр: Ер нь Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд харьяалагддаг энэ 4 байгууллагын төсөв бас боломжийн хэмжээгээрээ нэмэгдээд улс орны эдийн засгийн ерөнхий байдал чадавхтай уялдаад бас боломжийн нэмэгдсэн байна гэж ингэж үзэж байгаа юм. Гадаад харилцааны чиглэлийн асуудал дээр бас их онцгой анхаарах хэрэгтэй. Улс орны эдийн засгийн амьдрал шууд гадаад харилцаатай шууд холбогдож байна шүү дээ бол.

Тийм учраас энэ дээр анхаарах шаардлагатай. 32 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа юм байна. Урсгал зардал нь 19-өөр, хөрөнгийн зардал нь 13-аар нэмэгдэж байгаа юм байна.

Тэгэхээр энэ гадаадад сууж байгаа дипломат төлөөлөгчийн газруудын байршил ер нь ямар байгаа юм бэ. Яаж тооцож, яг өнөөдрийг оновчтой зөв зөв байж чадаж байна уу үгүй юу? Тодорхой хэмжээний хэмнэлтүүдийг гаргах, шаардлагатай газар дээрээ нэмэх ийм боломжууд ямар байгаа юм гэсэн эхний асуулт байгаа.

Зүгээр энэ 4 байгууллагатай хамаарахгүйгээр надад ганц хоёр асуулт байна. Энэ Сангийн яам задаргаага орлогынхоо задаргааг өгмөөр байна. Яг энэ 25 их наяд төгрөг, 27 их наяд төгрөг байгаа шүү дээ. Нөгөө Төсвийн тогтвортой тогтворжуулалтын сан, Ирээдүй өв сан 2-ыг хасаад 25 их наяд. Тэгэхээр энэ задаргаанууд ААНОАТ-аа яаж тооцсон юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт онцгой албан татвар юу юунаас нефть бүтээгдэхүүнээсээ

хэчнээн юм. Тэр спирт согтууруулах ундаанаасаа хэчнээн юм? Тэгээд энэ задаргаанууд хэрэгтэй байна. Энийг өгөөч. Энэ нэг их нууц биш байх гэж бодож байна. Энэ задаргаануудыг маш сайн тооцож би хармаар байна энэ тооцоог өгөөч гэсэн ийм юу байна.

Дараагийн асуудал бол юу вэ гэхээр энэ яах вэ ер нь бол төсөв төлчихлөө энэ тэр гээд л төсөв төлөөгүй ер нь боломжийн хэмжээнд оруулж ирж байгаа энэ энэ 27 их наяд төгрөг гэдэг бол бас боломжийн тоо оруулж ирж байна гэж бодож байна. Сайн байна. Энэнээс илүү боломж бол байгаа. Жил жилийн төсөв дээр бол бололцооноос дутуу төлөвлөөд байна гэж ярьдаг байсан. Энэ жил бол маш сайн ингэж оруулж ирж ингээд цаашаагаа явах ёстой. Мөнгөний бодлоготойгоо уялдахгүй байгаа. Мөнгөний бодлогынхон юу гэж байна? Банк банкныхан нь юу гэхээр 23 их наяд төгрөгөөс хойш нэг хувийн инфляц нэмэгдэнэ гэж байгаа юм.

Ингээд тооцохоор нэг 12-оос 13 хувийн инфляц болох гээд байгаа юм. Энийг яаж тооцож байгаа юм Жавхлан сайд энэ дээр хариулаач.

Төгсгөлийн асуудал бол юу гэхээр маш их хэмжээний баялаг гарах нь ээ. 60 сая тонн нүүрс, 20 тонн алт, 8.5 сая тонн төмрийн хүдэр, 60 тонн нүүрс гээд ингээд. Тэгээд энэ гарч байгаа баялаг маань бол үр өгөөж нь ер нь ямар байдаг юм бэ? Энэ дээр юу гэхээр нөгөө бид нар маржсен гэдэг юм тавих гээд байгаа юм л даа. Хамгийн хямд түлш энд Монголд хэрэглэж байна. Ажиллагсдын зардал хамгийн бага нь Монголд хамгийн бага эрчим хүч хэрэглэж байна. Хамгийн бага газрын төлбөр төлж байгаа. Нийт борлуулалтаас зардлаа хасахаар нэг үйл ажиллагааны маржсен гэж юм гарна. Үйл ажиллагааны маржсенгаас тэр нэг ашигийн маржсен гарч ирнэ. Энийг тооцож байна уу? Манай Сангийн яам тооцдог юм уу? Тоо хэлээч 2022 онд ямар байсан? 2023 оны ХБ гүйцэтгэл юу байна. 2024 онд яаж

тооцож байгаа юм? Энэ тоонуудыг хэлээч. Ийм асуултуудад хариулт авъя. Тэгээд нэмэлт цаг дээр асуултаа.

Н.Энхболд: Анхбаяр дарга эхлээд хариулъя тийшээ очоод суучих уу? Нэг номер дээр очоод суучихъя.

Дараа нь Жавхлан сайд бэлдэж байгаарай.

Н.Анхбаяр: Баттөмөр гишүүний 2 асуултад хариулъя.

Гадаад харилцааны яамны төрийн нарийн Анхбаяр 1 дүгээрт байршил оновчтой байгаа юу хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрууд гэдэгт ерөнхийдөө бол оновчтой байгаа гэдэг зөв зүйтэй байгаа гэдэг хариултыг өгмөөр байна.

Уламжлалт харилцаатай Лаос, Куб гэх мэт орнуудад бол бид нар Элчин сайдын яамаа хаахгүй. Харин цөөн орон тоотойгоор байнгын авч Хойд Солонгос гэх мэтчилэн ийм улс орнуудтай бол байнга авч явах нь зүйтэй гэж бодож байгаа. Цаашидаа их тэлэхгүй. Гэхдээ үнэхээр шаардлагатай газруудад одоо жишээлбэл геополитикийн нөхцөл байдалтай уялдуулаад Төв Азийн орнууд руу бас харилцаан дээрээ онцгой анхаарах ийм шаардлага байна. Тэр ч утгаараа хоёр 7 хоногийн өмнө Ташкентад буюу Узбекистан улсад Элчин сайд яам нээх асуудлыг Байнгын хороотой зөвшилцсөн байгаа.

Бид яам болон төв болон ДТГ дээрээ төрийн хэмнэлтийн хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл батлагдсан төсвөө яг хуулийнх нь дагуу хэмнэлттэйгээр ашиглаж байгаа. Зарчим нь юу вэ гэхээр батлагдсан төсвийг тэр чигээр нь зарцуулах биш хэмнэж болох зүйлийг хэмнэж илүү үр ашигтай ажиллах ийм зүйл байна. Нөгөө талаасаа сая бас Францад хийсэн төрийн тэргүүний айлчлал нэлээн амжилттай боллоо. Зүгээр сонирхуулж хэлэхэд

Францад манай Элчин сайдын яам 7 орон тоотой ажиллаж байгаад, сая Консулын хэлтэс нэмж нээсэн. Жилийн төсөв нь 609 мянган доллар байна. 609 мянган доллар. Гэтэл саяын айлчлалаар одоо эдийн засгийн үр өгөөж гэх юм бол маш өндөр тооны ийм хэлэлцээ нөхцөлийг бүрдүүлж байна гэж хариулах байна аа. Өөрөөр хэлбэл, үр өгөөжтэй харилцаа, хамтын ажиллагаа бага орнуудад бол бага орон тоотойгоор шаардлагатай бусад орнууддаа бол орон тоог нь өсгөх дотооддоо зохицуулдаг ийм байдлаар ажиллаж байгаа.

Баярлалаа.

Н.Энхболд: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Бид танд орлогын задаргааг эдийн засгийн ангилал бүрээр, татварын ангилал бүрээр дахиж хүргүүлж ээ. Энэ манай төсвийн танилцуулга нэлээн зузаан хэвлэгдэж гарсан байгаа. Үүний 44-өөс 60 дугаар хуудсан дээр орлогын талаар нэлээн дэлгэрэнгүй мэдээллүүд байгаа. Энийг тусад нь танд өшөө дахиад боломжоороо задлаад хүргүүлжэ. Ажлын хэсэг дээр мөн яг зөвхөн орлого тал дээрээ дахиад дэд ажлын хэсэг байгуулагдсан. Тэрэн дээр мөн мэдээллүүдтэй бид нар нээлттэй ингээд ажиллаад явж байгаа. Аж ахуйн нэгжүүд дээр ялангуяа томоохон аж ахуйн нэгжүүд маань манай ер нь 60 мянган компани бүртгэлтэйгээс 400 компани манай татварын орлогын 70 хувийг, 70 гаруй хувийг ингээд бүрдүүлж байдаг. Бид ер нь сүүлийн жилүүдэд компани бүрээр бараг ингэж гаргадаг болсон байгаа.

Үүнд төрийн өмчийн үйлдвэрийн газрууд ч байна, хувийн хэвшлийн компаниуд ч байгаа. Эрчим хүч болон тээвэр гээд яг улсаас тарифыг нь контролдог бид байнга хяналтдаа байлгадаг ийм салбарууд бол бас байдаг. Хэрвээ энэ үнэ тарифуудыг хэрвээ

чөлөөлөх юм бол хувийн хэвшил талдаа бас нэлээн тийм хүнд тусахаар ийм байдаг. Яах вэ олон жилийн бодлогоор бид нар ингэж л явж ирсэн л дээ. Иймэрхүү тооцооллууд бол компани бүрээр байгаа. Тэгээд шаардлагатай бол бид танд хүргүүлье. Орлогын хувьд бол яах вэ ерөнхий тоонууд гэх юм бол бид ирэх жил, уул уурхайгаас 8 их наяд төгрөг буюу манай төсвийн төсөвлөсөн орлогын 30 хувь нь орж ирж байгаа. Энэ өмнөх жилийнхээс даруй бараг 4 их наядаар нэмэгдэж гарч байгаа ийм тоо. Тэгэхээр тэр хэмжээгээр экспорт нэмэгдэх хэрээр байгалийн баялгийн төсөвт төвлөрүүлэх өгөөж нь нэмэгдэж байгаа ийм өөрчлөлт юм аа.

Нэмэлт мэдээлэл тоонууд дээр Санжаа дарга хэдэн тоонуудаа танилцуулаадаг аа.

Н.Энхболд: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, 1 дүгээр микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Баттөмөр гишүүний асуултад хариулъя аа.

Тэгэхлээр уул уурхайгаас орж ирж байгаа орлогыг бид нар 8 их наяд гэж тооцсон. Үүнээс бол 1.4 их наяд нь бол АМНАТ-ын орлого, 480 тэрбум бол аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, ноогдол ашиг 458, гааль, татварын хураамжаар 123, бусад орлогоор бол 276.4 тэрбум төгрөг гээд ингээд тооцсон байгаа. Зэсийн хувьд бол. Мөн үүнтэйгээ уялдсан байдлаар нүүрсэн дээр, алтан дээр гээд бусад чиглэл бүрээр нь бол бид нар орлогыг бол тооцож гаргаж байгаа. Нийт дүнгээр нь хэлэх юм зэсээс бол 2.7 их наяд, нүүрснээс 4.3 их наяд, алтнаас 292, бусад үнэт металл уул уурхайн салбарын бүтээгдэхүүнээс бол 648.3 тэрбум төгрөг гээд ингээд нийтдээ 8 их наяд төгрөгийн орлого бол олно гэж бол тооцсон байгаа.

Н.Энхболд: Баттөмөр гишүүн модотгоё.

Б.Баттөмөр: 8 их наяд ч бол яах вэ дээ ингээд л орж ирээд л байдаг ойлгомжтой. Би үр ашгийн асуудал яриад байна шүү дээ асуугаад байна шүү дээ. Ямар үр ашигтай ажиллаж байна. Уул уурхайн нөхцөл байдал хүндэрч байна гэдэг. Энэнтэй уялдаад энэ үр ашгийн асуудал асар их хэмжээний. Энэ чинь 6.2-оороо бол нөгөө газрын доорх баялаг чинь ард түмний мэдэлд байдаг шүү дээ.

Үр ашиг ямар байна? Тийм судалгаа байна уу л гэж асуугаад байна шүү дээ. Өнгөрсөн жил ямар байсан энэ жилийн кибер гүйцэтгэл ямар байх нь вэ? 2024 онд яаж тооцов. Маржен мэдэж байгаа биз дээ тийм ээ. Үр ашгийн нөгөө зорилгоо тодорхойлох харьцаа гэж эдийн засгийн шинжлэх ухаанд үздэг шүү дээ. Өнгөрсөн жил би асуусан та нар хариулаагүй. Энэ жил ахиад асууж байна. Хариулахгүй л байна. Бэлэн бус бол.

Н.Энхболд: Хариулах уу? Санжаадорж 1 дүгээр микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Тэгэхлээр орлогыг бүрдүүлж байгаа болон манай ДНБ-ийг бүрдүүлж байгаа томоохон үйлдвэр компаниуд салбаруудын нэгж бүрээр нь бол бид нар тооцоо судалгаа хийж үздэг. Ялангуяа бид нар илүү голчилж үздэгүүд нь бол үнэ тарифыг Засгийн газраас илүү оролцоотойгоор тодорхойлдог. Зах зээлийн зарчмаараа явдаггүй ийм салбарууд дээр бид нар тооцоолол хийдэг. Жишээ нь эрчим хүчний салбар байна. Эрчим хүчний салбар дээр бол тооцооллыг бол үнэ тарифыг бол бид нар хэдэн хувьд байхад Засгийн газар аваад явах боломжтой вэ? Төсөв дээрээ аваад явахад дарамтын хувьд ямар байх вэ

гэдгийг тооцдог. Хэдэн төгрөгөөр борлуулалтын нийт өртөг нь гарч байна.

Дээрээс нь борлуулж байгаа бүтээгдэхүүнийх нь нэг нэгж нь бол хэдий хэмжээний өртөгтэй байна. Энэ хоёроороо бол алдагдал нь хэд байна гэдгийг бол тооцож явдаг. Одоогоор бол эрчим хүчний салбар дээр бол хамгийн өндөр алдагдалтай .../минут дуусав/.

Н.Энхболд: Баттөмөр гишүүн дахиад нэг тодруулчихъя.

Б.Баттөмөр: Яах вэ эрчим хүч дээрээ бүх салбар дээр тооцох нь зөв л байх. Гэхдээ уул уурхайн салбар бол онцлог. Тийм ээ уул уурхайн салбар онцлог. Түрүүн яриад байна шүү дээ. Дэлхийн зах зээлийн үнээр бид нар бараа бүтээгдэхүүнээ худалдаж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ. Алт, зэс гээд тийм ээ нүүрсэн дээр бол бүс нутгийн зах зээлийн үнээр явж байгаа байх. Үр ашгийн асуудал яриад байгаа юм. Ямар хэмжээний борлуулалт хийгээд тэр 8 их наяд төгрөгийг ямар хэмжээний борлуулалт хийнэ гэж тооцоод тэгж хийсэн юм бэ. Жил жилээ харьцуулсан үр ашгийн юмнуудыг нь яаж тооцож байна л гэж асуугаад байгаа юм. Байгаа нь онохгүй л хариулаад байна л даа та нар. Тэр тооцоогоо хийж үзүүлээрэй.

Н.Энхболд: Баттөмөр гишүүнд тэр тооцоог нь гаргаж өөрт нь хүргүүлээрэй Санжаадорж дарга аа.

Бат-Эрдэнэ гишүүн асуултай тавья.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа би 2, 3 зүйл хэлээд орхиё. Нэгдүгээрт мэдээж улсын төсөв арвилан хэмнэлттэй үр ашигтай байх ийм үндсэн зарчим байгаа эндээ хэр нийцэж байна аа? Төрийн хэмнэлтийн хууль гээд сайн хууль гарсан. Энэний бодит үр дүн тооцоо байгаа юу? Энийг Сангийн сайдад нэг хэлж өгөөч ээ гэж. Дараагийнх нь юм бол энэ төрийн албаны салбар болгоны одоо харьцаа,

цалин, нийгмийн баталгаа ялгамжгүй байх энэ зарчимтайгаа хэр нийцэж байна гэдэг ийм зүйл. Энэ чинь үндэсний Аюулгүй байдлын зөвлөмж гарчихсан. Ер нь Засгийн газраас л цалин, нийгмийн хамгаалал баталгаатай холбоотой асуудлыг л тооцож оруулж ирэхдээ ийм үндсэн зарчим байгаа шүү дээ. Өмнө нь бол бид нар яасан гэхээр зэрэг л ерөөсөө дур дурын хууль санаачлах эрхтэй Их Хурлын гишүүд нэг салбарын хууль барьж орж ирээд л тэгээд л агентлаг нэмдэг, орон тоог нэмдэг, цалин нийгмийн баталгааныхаа асуудлыг нь ингэж уралдаж нэмсээр байгаад л өнөөгийн ийм нөхцөл байдал руу орсон байгаа юм. Нэг ийм зүйл хэлж өгөөч ээ гэж.

Дараагийнх нь асуудал бол энэ Гадаад харилцааны яам төсөв 32 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа гэж байгаа юм. Гэтэл хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгө тун чамлалттай ийм л байх шиг л санагдаад байх юм 400 сая төгрөг өмнөх оныхоос бол 7.9 сая төгрөгөөр тийм ээ энэ чинь 400 сая төгрөг биз дээ. Тэгээд ийм байх юм. Тэгээд энийгээ одоо цааш нь яах юм бэ?

Энэ иргэдийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой асуудал чухал байх гэж ингэж үзээд байгаа юм. Манай биеийн тамирын салбар бол ингээд нэг яамдад хуваарилагдаад тэгээд нэг яамны ахлах мэргэжилтнээс ер нь цааш нь гарч чадахгүй байсан. Ийм л түүхтэй юм л даа. Тэгээд тэрний тодорхой жишээ л бол энэ Нийслэлийн 9 дүүрэгт бид нар Их Хурлаас мянган хүний суудалтай мянгаас доошгүй хүний суудалтай усан бассейнтай спортын ордууд барина гээд ингээд зорилт болгоод тавьчихсан. Аймгийн спортын заал ордныг шинэчлэх ийм зорилт тавьчихсан. Гэтэл арван хэдэн жил болчихсон энийгээ гүйцээж чадаагүй.

Жавхлан сайд бид 2 Дарханд очиж ажигласан. Амарсайхан Шадар сайдтай энэ Баянзүрх Налайхын спортын ордуудаар явж ажигласан. Тэгээд энийг

гүйцээхтэй холбоотой тэр Баянзүрхийн спортын ордон бол яг орчмын тэр үерийн аман дээр юм байна лээ л дээ. Тэгэхээр энэ үерийн далангийн 2.7 тэрбум төгрөг тусгуулсан. Тэр зөвхөн тэр Спортын ордныг хамгаалах гэж байгаа асуудал биш. Тэр орчмын байгууллага иргэд тэр уулын ам түшсэн тэр орчмыг хамгаалахтай холбоотой энэ зардал ер нь хаана явж байдаг бол Манай Сангийн яамныхнаас энд хэлэх бололцоо байна уу, үгүй юу гэж. Нөгөө талд нь бол ер нь үе үеийн парламент энэ биеийн тамир спортын заал танхимуудыг бол Их Хурлын гишүүд л хөөрхий минь санаачилж байж оруулдаг юм. Энэ жил бас л ялгаа байхгүй хэд хэдэн сумдад энэ захын алслагдмал хороодод ингээд биеийн тамирын заал санаачлаад орсон. Тэр нь төрийн хэмнэлтийн хууль бусад хуультай холбоотойгоор ингээд оруулах батлуулах тийм нөхцөлгүй болчихсон юм яригдаж байна.

Дараагийнх нь нэг юм бол энэ магадлал хийгдсэн аудит зураг төсөв нь тодорхой байх ёстой энэ зарчим зөв. Гэхдээ оройтоод аудитын газраас гарсан тэр маш олон манай салбарт гэхэд л олон асуудлууд байж байгаа юм. Тэгээд энийг яах юм бэ гэдэг нэг асуудал. Хамгийн сүүлд нь бол би юу хийх гэж байгаа гэхээр түрүүн хээрийн эмнэлэгтэй холбоотой юм. Ингээд хээрийн эмнэлэг ингээд хувьдаа завичихсан ч юм шиг ийм нийгэмд ойлголт гаргаад их удлаа шүү дээ. Үгүй ээ энэ төрийн албыг хариуцаж байгаа энэ улсууд дор нь нийгэмд гараад мэдээлэл яагаад өгч болдоггүй юм бэ?

Н.Энхболд: Хэмнэлтийн хуультай холбоотой асуудал, биеийн тамир спортын байгууламжуудтай холбоотой асуудлыг Жавхлан сайд хариулъя. Магадлан дүгнэлттэй холбоотой асуудлыг аудитынхан бэлдэж байгаарай. Наранчимэг дарга. Хээрийн эмнэлэг түрүүн ярьсан нэмэх хүн байвал бас хэлж болно оо.

Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Төрийн хэмнэлтийн хууль бид маш сайн хууль цаг хугацаагаа онож 2 жилийн өмнө гаргаж байсан. Энүүний үр дүн бол маш сайн байгаа маш сайн байгаа. Маш сайн гэдэг нь манай хүчний байгууллагууд дээр Батлан хамгаалах яам болон бусад ТТ-ийн чиглэлийн хүчний байгууллагууд дээр ер нь үлгэр жишээ байдаг. Энэ байгууллагууд маань өөрсдөө хуулиа маш сайн нарийн чанд сахилга баттай барьдаг, дээрээс нь тушаалаар явдаг ийм байгууллагууд. Үнэхээр үлгэр жишээ байдаг. Хувцсаа сольж чадахгүй хэмжээний хэмнэлттэй 8 жил ажилласан. Ирэх жилээс энэ чинь арай бас ингэж дахиж зүтгүүлж болохгүй. Тийм учраас бид Батлан хамгаалах яаман дээрээ хэрвээ зүгээр хөрөнгө оруулалт болон бусад ингээд урсгал зардлуудыг нь харах юм бол бас нэлээдгүй өсөлттэй байгаа нь Батлан хамгаалах яам байгаа. Тэгэхдээ төсөв нь бага л даа өөрөө хэмжээ нь өөрөө бага бусад яамдуудтай харьцуулбал.

Тийм учраас хэмнэхдээ хэдүүлээ бас учиртай хэмнэхгүй бол батлан хамгаалахын болон энэ хүчний байгууллагууд дээрээ ингэж удаан бас хамаагүй хэмнэж болохгүй юм байна лээ.

Тийм учраас энэ жилийн төсөв бол арай өөр байгаа шүү.

Спорт заал дээр хэдүүлээ нэг тоо ил гаргах ёстой байгаа. Бат-Эрдэнэ сайд энэ дээр онцгой анхаарч бид нар ийм чиглэл хариуцдаг сайдтай болсны үр дүнд бас энэ жил нэлээдгүй спортын чиглэлийн хөрөнгө оруулалтууд тавигдаж байгаа. Харин бас хэлэлцэх шатанд бас жоохон тэрийг чинь ад үзэх шинжтэй байна лээ шүү. Тэгэхээр та эд нарыгаа бас сайхан хамгаалаад гарна байх гэж найдаж байна. Ер нь эмнэлэг чухал л даа. Бид нар чадлаараа л эмнэлэг барьж байгаа. Зүгээр харин эмнэлэг дээр бага очихын тулд эрүүл байх хэрэгтэй тийм ээ. Тэгэхээр нийтийн биеийн тамир спортын чиглэлийн хөрөнгө оруулалт энэ юм руугаа

бас онцгой анхаарах ёстой. Тэр тоонууд дээр Чимэдээ дарга нь тоонууд хэлээдхээрэй.

Цалин дээр бол бид нэг кабинетын нөхдүүд энэ нэг хөрөөний ир шиг болоод ирчихсэн олон жил явчихсан энэ төрийн албаны энэ цалингийн нэгдсэн бодлого алдагдчихсан байгааг бид нар сүүлийн 2 жил янзлах гээд л ингээд л зүтгээд байгаа. Аль болох тэр салбар салбарынх нь хууль дээр орчихсон байгаа. Тэр цалин, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой юмыг нэгдсэн байдлаар явуулъя гээд. Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гаргасан байгаа. Зөвлөмж гаргасан. Гэхдээ нэг мөр бүх хуулиуд дээр нь бид нар янзалж чадахгүй байна. Ямар ч байсан ирэх жил ингээд нэг зохицуулалт хийх гээд энэ төсвийн 4.9 их наяд төгрөгийн энэ нэмэлт ирэх жилийн зардлын 65 хувь нь шүү 3.4 их наяд нь энэ цалин, тэтгэвэр, тэтгэмжийг жигдлэх тэр зөрүүнүүдийг арилгах ийм чиглэлээр төсөв маань өссөн байгаа. Тийм инфляцтай уялдуулж байна уу гээд бид аль болох инфляцтайгаа уялдуулахыг хичээж ажиллаж байгаа. Бид төсвийнхөө давсан орлого. Энэ их уул уурхай дагасан хатуу боловч шат дараатай цаг үеэ олсон арга хэмжээний үр дүнд төсвийн нэмэгдэл энэ боломжуудыг хамгийн эхэнд цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх энэ төсвийн бодлого руугаа шингээж байгаа. Гэхдээ бас энийг инфляцтайгаа уялдуулахгүй бол болохгүй. Сая 7 сарын 1-ээр 8 сараас эхэлж эффект нь орж ирж байна. Ирэх жил бид нэмэхдээ учиртай нэмнэ ээ. Бас ингээд шууд гуравхан сарын дараа 1 сарын 1-нээс нэмчлэлгүй, инфляцынх нь эффектийг нь гаргаж байгаад 4 сарын 1-нээс нэмбэл бодит нэмэгдэл болох нь ээ.

Тэгэхгүй бол наана нь нэмчихдэг, инфляцыг буцааж өдөөгөөд нөгөө нэмсэн ч биш инфляцаа идэгдээд ингээд явчих юм байгаа юм.

Дээрээс нь бид мөнгөний бодлоготойгоо нийцсэн ийм арга хэмжээ

сонгодог тохиолдол юу болсон бэ гэвэл өнгөрсөн жил ер нь сүүлийн.

Н.Энхболд: Жавхлан сайдад микрофон өгье.

Б.Жавхлан: Ингээд өнгөрсөн онд бид үндсэндээ 3 жил мөнгөний хатуу бодлоготой, төсвийн хэмнэлтийн бодлоготой явж байна. Ингээд 2022 онд бид төсвийн давсан орлого 1 их наяд болсон, 1 их наяд. Энүүгээр бид нар өөр урсгал зардал юм уу хөрөнгө оруулалтаа нэмэлгүйгээр мөнгөний бодлогын хатуу бодлоготой уялдуулж өнгөрсөн жилийнхээ төсвийн алдагдлыг нэг их наядаар шууд бууруулсан байгаа. Энэ бол яг мөнгөний бодлоготойгоо уялдаж байгаа ийм сонгодог тохиолдол гэж харж байна. Энэ жил ч гэсэн ер нь бид хагас жилээр төсвийн орлого давж биелээд тодотгол хийсэн. Тодотгол хийсэн ч сүүлийн улирлын өнөөдрийн 10 сарын байдлыг харах юм бол бас дахиад давж гарахаар байна.

Энийг бол одоо бид төсвийн алдагдлаа бууруулахад зориулах болно. Энэ бол яг мөнгөний бодлогын хатуу төлөвтэй яв цав нийцэх ийм зүйл болно.

Н.Энхболд: 3 номер аудит уу? Хэн хариулах юм? Нэг номер нэрээ хэлээд, албан тушаалаа хэлээд. Нэг номерын микрофон ажлын хэсэг.

Д.Энхболд: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Үндэсний аудитын газар Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал Энхболд. Үндэсний аудитын газраас Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолын дагуу төсөвт өртгийн зөрөөн дээр бол аудит хийсэн байгаа. Сангийн яам болон төсвийн ерөнхийлөн захирагчдаас нийт 480 арга хэмжээний жагсаалт ирсэн. Энэнээс аудитаар 3 удаагийн дүгнэлтүүдийг Барилгын хөгжлийн төв, Замын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төвөөс ирсэн

магадлал үндэслэлтэй байна уу гэдэг дээр бол аудит хийсэн. Төсөв өргөн баригдахаас өмнө нийт 211 төсөл арга хэмжээ ирсэн. Энэ арга хэмжээнүүдэд төсвийн төсөлд суугаад явсан. Төсөв өргөн баригдсанаас хойш 73 арга хэмжээний материалууд ирсэн. Энийг бол 10 сарын 18-нд Үндэсний аудитын газраас дүгнэлтийг гаргаж бол Төсвийн байнгын хороо болон Сангийн яаманд хүргүүлсэн байгаа. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын ажлын дэд хэсэг дээр энэ асуудлууд бас хэлэлцэгдэх байх.

Ер нь аудитын магадлалын ерөнхий дүгнэлт дээр Үндэсний Аудитын газраас дүгнэлт хийснээр бол нийт магадлалын дүнгээс 73.8 тэрбум төгрөгийн бол зардлыг бол бууруулсан ийм дүгнэлтүүд хийсэн байгаа.

Н.Энхболд: Бат-Эрдэнэ гишүүнээ нэмж асуух уу? 3 номер.

Ч.Чимидсүрэн: Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимидсүрэн Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя аа.

2024 оны хөрөнгө оруулалтыг бид төлөвлөхдөө бол ер нь дэд бүтцийн салбарт илүү хөрөнгө оруулалт болж эдийн засгийг дэмжих мөн хот хөдөөгийн сэргэлтийг дэмжсэн бодлого мөн иргэдийн оролцоонд тулгуурласан хөрөнгө оруулалтын бодлогуудыг баримталсан байгаа. Яг спортын салбарт бол нийт 54 төслийн 82.4 санхүүжих дүнтэй хөрөнгө оруулалт батлагдсан. Түүний 11 нь бол шинээр тавигдсан хөрөнгө оруулалт байна.

Н.Энхболд: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би түрүүн цаг багтаагүй учраас би нэмж юм асуух гээд байгаа юм. Сангийн сайдаас энэ өрийн удирдлага үнэ харилцаа ер нь ямархуу түвшинд байгаа юм бэ? Яах вэ

одоо 2012 онд бол улсын эдийн засгийн өсөлт 17 хувьтай, гадаад нэр хүнд бас бололцоотой байх үед тэгээд тухайн үед эрх барьж байсан нөхдүүд маань бол тийм арилжааны зээлүүд, их богино хугацаатай, өндөр хүүтэй, эцэг өвгөдийнхөө их сайхан нэрийг өгсөн. Чингис юу юу ч билээ ийм бондууд авч гаргаад, тэгээд тэрийгээ одоо ингээд зараад дууссан. Тэр нь бол Хөгжлийн банкаар дамжсан Хөгжлийн банкны асуудал гээд энэ чинь бараг 2 жилийн өмнө Их Хурал дээр өчнөөн асуудал болгож байж нэг ажлын хэсэг гаргаад ингээд явлаа шүү дээ. Тэгээд тэрний үр дүн ер нь бараг тун бага шиг. Яах вэ зүгээр мэдэх хэргийнхээ хүрээнд иргэд маань нэлээн юу болоод өнгөрснийг нь мэдсэн байх.

Үр дүн шийдвэр бол ер нь тун багатай шиг. Гэлээ гэхдээ энэ ажлын хэсэг байгуулсан, Түр хороо байгуулсан энэний үр дүнд Хөгжлийн банкныг дампуурлаас ямар ч байсан аварсан. Нэг их наяд гаруй чанаргүй зээл эргэн төлөгдөх юмнуудыг нь шахсан, ийм үр дүнтэй л боллоо л доо. Одоо бол юу гээд байна вэ гэхээр зэрэг би хөдөө гадаа явлаа. Тэгээд өргүй Монгол гэсэн үү, юу гэлээ өрнөөс сална гээд нөгөө нэг тийм юм яриад явах юм. Одоо ингээд манай танайх гээд л бие бие рүүгээ түлхээд л нэг улс төрийн нэг тийм өнгө аястай. Тэгэхээр зэрэг яг энийг бүр тодорхой гаргаад тэгээд хэдийг нь зохицуулалт хийж байж дарсан юм, яг хэдийг нь энэ Монголын ард түмэн нөгөө зүтгэж байж энийг дарсан юм? Ямар нөхцөл байдалтай байгаа юм? Нөгөө хуулиар зааж байгаа өрийн тааз элдэв тухай юмнууд чинь яг тэр хэмжээндээ байгаа юм уу? Энэ талаар бол нэг нэгдсэн ойлголт мэдээлэл өгөхгүй бол нөгөө хээрийн эмнэлэг шиг дахиад л нэг өөр тийшээгээ асуудлууд яригдаад байна аа.

Тийм учраас Сангийн сайдыг албан ёсоор нэг хариулт тодорхой хариулт өгөөч ээ гэж би ингэж хүсээд байгаа юм.

Н.Энхболд: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тийм Бат-Эрдэнэ сайд их зөв сэдэв хөндлөө. Ер нь нөгөө хэрэг тарьсан улсууд тэнд өр зээлээ яриад ингээд гайхаад яваад байгаа юм байна лээ. Тэрийг нь бас нэг сайн сануулж өгөхгүй бол ер нь нэг ойр ойрхон сануулж өгч байхгүй бол болохгүй юм байна лээ.

2010 оноос хойш нийтдээ 8 удаа Засгийн газар бонд гаргасан байдаг юм. Тэрний ерөөсөө эхний 3 нь л төсөл хөтөлбөр санхүүжүүлэх зорилготой. Тэрнээс хойших нь бол дандаа энэ өмнөх бондуудаа хугацааг нь хойшлуулсан хүүг нь багасгасан, дахин санхүүжилт хийсэн ийм бонд гаргасан юм. Ингээд манай Засгийн газар энэ гуравхан жилийн хугацаанд нийтдээ 12 их наяд төгрөгийн зээл төлсөн. Дахин санхүүжилт хийсэн. Үүний 4.8 их наяд нь дахин санхүүжилт хийсэн, бусад 6 их наяд нь.

Н.Энхболд: Минут нь багадаад байна аа. Жавхлан сайдын микрофоныг нэмж өгье.

Б.Жавхлан: Тийм тэгээд 12 их наядын өр зээлийг бид төлсөн байгаа. Гадаад өр гэж ярих юм бол хамгийн өндөр эрсдэлтэй үе нь улс төрийнх нь мөчлөгөөрөө бол 2012 оноос 2016 онд энэ хугацаанд манай гадаад зээлийн, гадаад өрийн хамгийн өндөр эрсдэлтэй үе байсан. Тэрнээс хойш бид нар дандаа төлж ирсэн. 1990 оноос хойш 4, 4 жилийнх нь мөчлөгийг нь харах юм бол энэ 4 жил бид хамгийн өндөр зээл төлөх цаг хугацааны хуваарьтай.

Дээрээс нь даинтай ковидтой гээд 9 шид нь бүрдсэн ийм 4 жил болчихсон. Гэсэн хэдий ч энэ улсыг бид нар дефолтод оруулчхалгүй, дампуурлыг нь зарлачхалгүй өнөөдрийг хүртэл авч ирсэн. Цаашидаа ч улам эрсдэлээ бууруулаад зээлжих зэрэглэлээ бүүр сайжруулах чиглэл рүү нь бид ингээд ажиллаад явж байгаа. Монгол Улсын өрийн хамгийн гол үзүүлэлт болох ДНБ-тэй эзэлдэг хувь хэмжээ 2015 онд 78

хувь хүрч ирсэн юм. Хамгийн өндөр эрсдэлтэй үе нь. Энийг бид нар энэ жил 45 болгож бууруулж байна хойтон 42 хувь болгож бууруулна. Монгол Улс ДНБ тэлэхийн хэрээр энэ гадаад өрийнхөө эрсдэл, даах чадамж нь улам их нэмэгдэж байгаа. Энэ нэмэгдэж байгаа хэрээр бид өөрөө тэлэхгүй байгаа. Харин хумьж, хэмнэж эрсдэлээ бууруулж ингэж явж байгаа гэдгийг албан ёсоор хэлье.

Тэгээд шаардлагатай индэр дээрээс энэ тоон мэдээлэл энэ бодлогоо бид дахин дахин ойр ойрхон хэлж ярьж байх болно оо.

Н.Энхболд: Баярлалаа. Тэр нэг хээрийн эмнэлгийн асуудал 2 ч гишүүнээс гарлаа та нар тэрийг нь тэгээд нэг ядаж хийсэн сургуулилтынхаа бичлэг юмыг сэтгүүлчид өгөөд юм уу, эс үгүй бол тусгайлан тийм ээ уриад энэ байгаа шүү гээд ингээд үзүүлчихэд болохгүй юм байхгүй шүү дээ. Тэгээд л нэг буруу ойлголт яваад л байх юм.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллагууд болох манай 4 газрын 2024 оны төсвийн төслийг төслийн 2 дугаар хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Дэгээрээ асуулт, гарсан хариултуудаа авлаа.

Зарчмын зөрүүтэй санал гараагүй бол ингээд манай хэлэлцүүлэг дуусаж байгаа юм.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Манай Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Манайхаас давхар байдаг гишүүн Баделхан гишүүн байгаа.

11.01 цагт

Баделхан гишүүнээр Төсвийн байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлье. Өнөөдөр Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууслаа. Оролцсон гишүүд ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*

Хуралдаан хаасныг мэдэгдье.